

5. Урагш харахад

ШШШ-наас урьдчилан сэргийлэх, хянах ажил нь тууштай байдал, асар их хөрөнгө оруулалт шаардсан урт хугацааны хүчин чармайлт билээ. Иймээс ч ШШШ-ны бүс нутгийн сүлжээг буй болгох болон загвар төслүүдийн хөрөнгө оруулалтын стратегийг хэрэгжүүлэхдээ үе шаттай арга хандлагыг авч хэрэглэх шаардлагатай байгаа юм. Зүүн хойд Ази дахь Шар шороон шуурганаас урьдчилан сэргийлэх, хянах төсөл (RETA 6068) –ийн хоёр бүрэлдэхүүн хэсэгт хэрэгжүүлэх үе шат бүхий арга хандлагуудыг тэдгээрийн судалгааны тайланд харуулсан болно. Эдгээр судалгаа нь Хоёрдугаар боть буюу Зүүн хойд Ази дахь ШШШ-ыг хянах болон урьдчилан мэдээлэх бүс нутгийн сүлжээг байгуулах нь, Гуравдугаар боть болох Загвар төслүүдээр дамжуулан ШШШ-наас урьдчилан сэргийлэх, хянах хөрөнгө оруулалтын стратеги болно.

Эдгээр хоёр судалгааг хийж дууссаны дараа оролцогч талууд болох БНХАУ, Япон, БНСУ, Монгол Улс, АХБ, НҮБ-ын ЦТК, НҮБ-ын АНДЭЗНК, НҮБ-ын БОХ зүүн хойд Ази дахь ШШШ-ны асуудлыг шийдвэрлэхэд бүс нутгийн хамтын хүчин чармайлт гаргах боломжийг хэлэлцсэн юм. Эхэн үедээ, техникийн туслалцааг

- (а) Бүс нутгийн хамтын ажиллагааны механизмд дэмжлэг үзүүлэх
- (б) ШШШ-ыг хянах, урьдчилан мэдээлэх чадавхийг бий болгоход дэмжлэг үзүүлэх
- (в) Төсөл боловсруулалт болон хэрэгжих боломжийн судалгааг хийж, хил дамнасан загвар төслийн зарим нэгэн сонгож авсан бүрэлдэхүүн хэсгүүдийг хэрэгжүүлэх замаар ШШШ-ыг багасгахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр боловсруулж хэрэгжүүлэх болсон байна.

Үүний зэрэгцээгээр, ШШШ-ыг бүс нутгийн санаачлагыг дэмжих зорилгоор засгийн газруудын хувь нэмэр бүхий ДДБОС-гийн багцыг боловсруулж болох юм. Мөн, ШШШ-наас урьдчилан сэргийлэх, хянахын ач холбогдол, одоогоор хэрэгжиж буй төслүүд, зарим хүчин чармайлтын үр дүнг харуулсан видео хөтөлбөрийг СД хэлбэрээр гаргаж танин мэдэхүйн чиглэлээр болон бусад хандивлагчид, ШШШ-нд өртсөн орнуудад үзүүлэх хэрэгтэй байна.

ШШШ-ны бүс нутгийн сүлжээ болон загвар төслүүдийн аль алинд шаардлагатай чадавхи бий болгохтой холбоотой санаанууд нь албан ёсоор

- (а) ШШШ-ыг хянах, мэдээлэл солилцох үйл ажиллагааны стандарт гарын авлага боловсруулах
- (б) Түнш орнуудын дунд ШШШ-ны симуляц болон урьдчилан мэдээлэх арга техникийн солилцоог дэмжих
- (в) Бүс нутгийн мэргэжилтэн шинжээчдийн сүлжээ болон сургалтын чадавхийг бий болгохыг дэмжих
- (г) Техникийн болон үйл ажиллагааны ажилтнуудад ажлын байран дахь сургалт явуулах
- (д) ШШШ-ыг бууруулах хамгийн сайн арга туршлага, практикийг хуваалцах, солилцохыг хөхүүлэн дэмжих туслалцаа үзүүлэх зэргээр баталгаажих юм.

Түнш орон бүрийн хувьд дараагийн алхам нь мастер төлөвлөгөөг хамгаалах асуудал бөгөөд энэ ажлын хүрээнд уг төлөвлөгөөг оролцогч орнуудын хэл рүү орчуулах ажил багтаж байна. Үүнээс гадна, хувийн хэвшлийг оролцуулаад оролцогч бүхий л холбогдох талууд (тухайлбал, Жэй-Грин¹) энэхүү төслийн загвар төслийн газруудад ШШШ-ыг бууруулахад чиглэсэн бэлтгэл судалгаа, үйл ажиллагааг хэрэгжүүлэх явдлыг бүрэн дэмжих болно.

¹ Жэй-Грин буюу J-Green нь Японы ногоон нөөцийн агентлаг буюу тус улсын ХАА, Ой, Загасны аж ахуйн яамны харьяа байгууллага болно.